



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 11 сарын 17 өдөр

Дугаар А/778

Булган сум

**Сарын аян зохион байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн ИТХ-ийн 2020 оны II/03 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2 дахь хэсгийн 2.1.6 заалт, аймгийн Засаг даргын А/593 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Бүртгэл, санхүү, эдийн засгийн ажилтны баярын өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх сарын аяныг төр, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудын нягтлан бодогчдын дунд 2023 оны 11 дүгээр сарын 07-ноос 12 дугаар сарын 09-ний өдөр хүртэл зохион байгуулсугай.
2. Сарын аяныг зохион байгуулах удирдамж, шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.
3. Сарын аянд шаардагдах 4,050,000 (Дөрвөн сая тавин мянга) төгрөгийг “Аж ахуйн нэгж байгууллагын бүртгэл хөтлөлт, стандарт нэвтрэлт, эрсдлийн удирдлагын чиглэлээр сургалт зохион байгуулах” арга хэмжээнээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2023 оны  
11 дугаар сарын 11-ний өдрийн  
А/778 дугаар захирамжийн 1 хавсралт

**“ТӨРИЙН АЛБАН ХААГДЫН ӨДӨР”, САНХҮҮЧДИЙН ӨДРИЙГ УГТАН  
ЗОХИОН БАЙГУУЛАХ САРЫН АЯНЫ УДИРДАМЖ**

2023.11.07

Булган сум

**Зорилго:** Аймгийн санхүүгийн салбарын албан хаагчдыг чадавхжуулах, мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах, эрх зүйн шинэчлэл харилцаа холбоог сайжруулах, нэгтгэхэд оршино.

**Хугацаа:** 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдөр.

**Хамрах хүрээ:** Төсөвт байгууллага, Аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодогч, санхүү бүртгэлийн ажилтан, санхүү, төрийн сангийн хэлтсийн харьяа ахмадууд.

**Зохион байгуулагч:** Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс, ММНБИ Булган салбар, томилогдсон ажлын хэсэг.

**Аяны хүрээнд зохион байгуулах үйл ажиллагаа:**

1. Төр, хувийн хэвшлийн байгууллагын нягтлан бодогчдыг чадавхжуулах сургалт зохион байгуулах (2023.11.11)
2. Санхүү, төрийн сангийн албаны “Дурсамж уулзалт” (2023.11.12)
3. Ерөнхий боловсролын сургуулийн 11, 12 дугаар ангийн сурагчдын дунд “Миний мэдэх санхүүч, эдийн засагч мэргэжил” эсээ бичлэгийн уралдаан (2023.11.01-2023.11.21)
4. Нягтлан бодогч, эдийн засагч, санхүүчдийн дунд “Орчин үеийн санхүүгийн мэргэжилтний олон талт ур чадвар” илтгэлийн уралдаан (2023.11.01-2023.11.25)
5. Нягтлан бодогч, эдийн засагч, санхүүчдийн дунд гар бөмбөгийн тэмцээн (2023.11.27-2023.11.29)
6. Санхүүчдийн баярын сарын аяны хаалт, шагнал гардуулах үйл ажиллагаа (2023.12.06-2023.12.09)

Аймгийн Засаг даргын 2023 оны  
11 дугаар сарын 14-ний өдрийн  
А.778 дугаар захирамжийн 2 хавсралт

**“ТӨРИЙН АЛБАН ХААГДЫН ӨДӨР”, “БҮРТГЭЛ, САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН  
АЖИЛТНЫ БАЯРЫН ӨДӨР”-ИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД  
ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

Д/д	Зардлын нэр	Нийт үнэ
1	Эсээ бичлэгийн уралдааны шагнал	160,000
2	Илтгэлийн уралдааны шагналын сан	300,000
3	Гар бөмбөгийн тэмцээний шагнал	500,000
4	Сургалтын зардал	3,090,000
	<b>Нийт дүн</b>	<b>4,050,000</b>